

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ,
БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН УЯЛДААТ БАЙДАЛ ДУТМАГ БАЙНА.

АУДИТЫН КОД: ӨВА-2025/27-14-ШТА-ГА

Өвөрхангай аймаг 2025 он



Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал

Утас: 7032-3253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер П.Хорлоосүрсэн

Утас: 7032-3108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах Аудитор: Ө.Ринчинмядаг

Утас: 7032-3833 Цахим хаяг: RinchinmyadagU@audit.gov.mn

Аудитор: Р.Энхзул

Утас: 7032-3833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

Аудитор: Д.Очирбат

Утас: 7032-3833 Цахим хаяг: OchirbatD@audit.gov.mn

Аудитор: Б.Нямсэмжаан

Утас: 7032-3833 Цахим хаяг: NyamsemjaanB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
авна уу: Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ	
МЭДЭГДЭЛ	7
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:	9
БҮЛЭГ 1. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД	
ҮНДЭСЛЭН ХИЙЖ БАЙГАА Ч ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛД	
ШИНЭЧЛЭЛ, САЙЖРУУЛАЛТ ХИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД НАРИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ	
ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	9
А.1. Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөснөөр зарим сумдад орлого бүрэн биелэхгүй, тасрах эрсдэл үүсэж байгаа тул хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийг харгалзах үзүүлэлтүүдийг тусган журамлах нь зүйтэй юм.	9
А.1.1. Хүүгийн орлогын төрөл зүйлийг нарийвчлан хуульчилж, журамлах шаардлагатай байна.	9
А.1.2. Торгуулийн орлогыг сумдын хүн амын тоо, алслагдсан байдал зэрэг тодорхой нарийн үзүүлэлтүүдэд тулгуурлан төлөвлөх нь зүйтэй юм.	10
А.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн, төлөвлөсөн ч Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг төлөвлөхдөө хульд заасан заалт, хувь хэмжээг баримтлаагүй; босоо тогтолцоотой байгууллагууд улс, орон нутгийн төсөв рүү харилцан адилгүй байдлаар торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.	10
А.2.1. Торгуулийн орлогын биелэлт нь зарим сумдад биелээгүй тасарсан байдалтай байна.	10
А.2.2. Орлогыг төлөвлөхдөө сүүлийн 3 жил тутмын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд дүгнэлт хийн, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.	11
А.2.3. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газартай эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний дагуу эргэн төлөгдөх хүүгийн төлбөрийг төсөвт төлөвлөж өгсөн ч ашиглагч тал нь хүүгийн төлбөрийг төлж чадахгүй байгаатай холбоотой аймгийн орлого тасарсан байна.	11
А.2.4. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлийн ангилал болон хувь хэмжээг баримтлаагүй байна.	11
А.2.5. Хүү, торгуулийн орлогыг аймгийн СТСХ, Татварын газар болон сумд тогтмол тооцоо нийлж байгаа ч орлогын ихэнх хувийг бүрдүүлэгч аймгийн Цагдаагийн газартай орлогын бүрдүүлэлтийн илүү, дутууг тогтмол тооцоо нийлээгүй, шалтгааныг бүрэн тодруулаагүй байна.	12
А.2.6. Нэгдсэн зохицуулалт байхгүйгээс шалтгаалан босоо тогтолцоотой байгууллагууд улс, орон нутгийн төсөв рүү харилцан адилгүй байдлаар торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.	12
А.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад тодорхой хэмжээнд нийцэж байгаа ч орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлагатай байна.	13
А.3.1. Торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байгаа боловч хүүгийн орлого бүрдүүлэлтийн эрх зүйн орчин дутмаг байна.	13
А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна.	15

А.3.3. Төсвийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудад торгуулийн орлогын талаар нарийвчилж тусгаагүй байгаа нь орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.....	16
А.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа боловч торгууль оногдуулах процессыг хялбар болгох хэрэгцээ шаардлага байна.	17
А.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна	18
А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.....	18
А.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөөгүй байна.	19

БҮЛЭГ 2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО НОГДУУЛСАН ДҮНГЭЭС ДУТУУ ТӨВЛӨРСӨН БА ГХУСАХ-НИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭНЭЭС ДУТУУ ХУВААРИЛСАН ХОЛБОГДОХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....20

Б.1. Ногдуулсан хүүгийн орлого бүрэн төвлөрөөгүй, торгуулийн орлого 2023, 2024 онуудад нийт 429.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.....	20
Б.1.1. Аймгийн хэмжээнд нийт 6 байгууллагын ЭБАТ-уудын тогтоосон торгуулиас 2023 онд 188.2 сая, 2024 онд 241.7 сая төгрөг тус тус дутуу төвлөрсөн байна.	20
Б.1.2.Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023, 2024 онуудад эрх бүхий 17 байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд торгууль тавьсан байна.....	21
Б.1.3. Аймгийн ТЭЗ-ийн санхүүгийн тайланд 2023 онд 12.3 сая төгрөг, 2024 онд 6.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг тус тус дутуу тайлагнасан байна.....	21
Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт эзлэх хувь харьцангуй бага байна.	22
Б.2. Хүү, торгуулиас бүрдсэн орлогоос ГХУСАХ-ний зардалд 359.3 сая төгрөгийг дутуу хуваарилсан бөгөөд холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай байна.	23
Б.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль, эрх зүйн үндэслэл бүрэн бүрдээгүй байна.	23
Б.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан дагалдах журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.	24
Б.2.3. Хүү, торгуулийн орлогыг ГХУСАХ-ний зардалд 2023, 2024 онуудад нийт 359.3 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.	24
Б.2.4. Албан хаагчдийн ажлыг дүгнэхдээ орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээг үзүүлэлт болгон дүгнэдэггүй байна.	26

БҮЛЭГ 3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН АЙМАГ, СУМАНД ЖУРАМД ЗААСАН ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БА ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ НАРИЙВЧЛАН БОЛОВСРУУЛЖ, ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....26

В.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан, нийгэм, эдийн засагт тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн байна.....	26
В.1.1. Аймаг, сумдад торгуулийн орлогыг холбогдох журмын дагуу үр ашигтай зарцуулсан ч журамд хуульд нийцүүлэн нарийвчлан заалтуудыг тусган, шинэчлэх шаардлагатай байна.	26
В.1.2. Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулсан гэж үзэх боломжгүй байна.....	27
В.1.3. Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд тодорхой хэмжээнд хүрсэн байна.	28
В.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2024 оны арга хэмжээ нь нийгэм, эдийн засагт эерэг нөлөөг үзүүлсэн байна.	28

В.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг ил тод мэдээлээгүй байна.
29

**БҮЛЭГ 4. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ
ХЯНАЛТ ДУТМАГ БАЙНА.30**

Г.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрдээгүй байна.
30

Г.1.1. Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.....30

Г.1.2. Цагдаагийн бэлэн бус торгуулийн төлбөрийн төлөлт бүрэн цахимжсан байна.
.....31

Г.1.3. Хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.31

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт, иргэн, ТББ, ОУБ, зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.31

Г.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан байна.....31

Г.2.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна.....31

Г.2.3. Орлого төвлөрүүлэгч байгууллагууд торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.31

Г.2.4. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад иргэн, ТББ, ОУБ, зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.32

ДҮГНЭЛТ33

ДЭЭД ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ33

ЗӨВЛӨМЖ34

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Хүснэгт 1
Хүснэгт 2
Хүснэгт 3
Хүснэгт 4
Хүснэгт 5

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХУСАХ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ОУБ	Олон улсын байгууллага
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХК	Хувьцаат компани
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсвийн орлогын ангилал (сая.төг).....	9
Хүснэгт 2. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)	9
Хүснэгт 3. Өвөрхангай аймгийн Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023, 2024 он (сая.төг)	10
Хүснэгт 4. Өвөрхангай аймгийн Торгуулийн орлогын төлөвлөгөө, биелэлтийг сумдаар 2022-2024 он (сая.төг)	11
Хүснэгт 5. Байцаагчдын торгууль тавьсан байдал, орлого төвлөрүүлж буй ангилал	12
Хүснэгт 6. Торгуулийн орлогын төвлөрүүлэгч байгууллагуудаас илүү, дутуу төвлөрүүлсэн байдал	20
Хүснэгт 7. Шийдвэрийн төрөл 2023, 2024 он	21
Хүснэгт 8. 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын дансны хуулганы зөрүү (сая.төг)	22
Хүснэгт 9. Аймгийн ТЕЗ-н 2023, 2024 оны санхүүгийн тайланд хүү, торгуулийн орлогын эзлэх хувь	22
Хүснэгт 10. Аймгийн татварын бус орлогыг аймаг, сумдаар задалж харуулбал /сая.төгрөг/	23
Хүснэгт 11. Хүүгийн орлого /сая.төг/	24
Хүснэгт 12. Торгуулийн орлого /сая.төг/	24
Хүснэгт 13. ГХУСАХ-ний 2023, 2024 оны зардлыг тооцсон дүн (сая.төг)	25
Хүснэгт 14. 2023, 2024 онд ГХУСАХ-ны зардлыг давхар хуваарилсан сумд	25
Хүснэгт 15. Хархорин сумын ИТХ-с зарцуулсан ГХУСЗ зарцуулалт (сая.төг)	27
Хүснэгт 16. Шилэн данс дахь хүүгийн орлогын мэдээлэл	30
Хүснэгт 17. 2023, 2024 онд шүүхээс албадан гүйцэтгүүлхээр хүргүүлсэн зөрчлийн тоо, дүн /сая төг/	31

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дүрслэл 1. Улсын байцаагч нараас авсан санал асуулга	14
Дүрслэл 2. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиас	16
Дүрслэл 3. Улсын байцаагч нараас авсан санал асуулга	17
Дүрслэл 4. Зөрчлийн тухай хуулиас	17
Дүрслэл 5. Улсын байцаагч нараас авсан санал асуулга	18
Дүрслэл 6. Улсын байцаагч нараас авсан санал асуулга	19
Дүрслэл 7. 2020-2024 онд бүртгэгдсэн зөрчлийн тоо	29

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. ГХУСАЗСЗТогтоол	30
--------------------------------	----

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит нэр:	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт
Аудитын код:	ӨВА-2025/27-14-ШТА-ГА
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:	Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 онд баталсан "Аудитын сэдэв батлах тухай" А107, "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт:	Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг Монгол Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Хүү, торгуулийн орлогын төлөвлөлт нь хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх; • Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг хууль, журамд нийцүүлэн төвлөрүүлсэн эсэх; • Хүү, торгуулийн орлогын зарцуулалт үр дүнтэй эсэх; • Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, хяналт хэрэгжүүлэх холбоотой тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулав.
Аудитад хэрэглэсэн арга зүй:	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт 6817-3:2020, 6817-5:2020, 6817-7:2020, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам болон Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудит, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг үндэслэн тулган баталгаажуулалтыг хийж, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж, аудитын асуудлын шинжилгээ болон арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт боловсруулан зөвлөмж бэлтгэлээ.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд: • Монгол Улсын Үндсэн хууль; • Төсвийн тухай хууль; • Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; • Нийгмийн даатгалын багц хуулиуд; • Татварын багц хуулиуд; • Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; • Гаалийн ерөнхий хууль; • Засгийн газрын тусгай сангийн тухай хууль; • Автозамын тухай хууль; • Зөрчлийн тухай хууль; • Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль; • Улсын бүртгэлийн тухай хууль; • Иргэний хууль; • Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль; • Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль; • Эрүүгийн хууль; • Байгаль орчныг хамгаалах тухай хууль; • Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль; • Төрийн аудитын тухай хууль; • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль; • Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”; • Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”; • Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”; • Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”; • Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”; • Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”; • Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”; • Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.
Аудит хийх багийн бүрэлдэхүүн	Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал хянан удирдаж, аудитын менежер П.Хорлоосүрэн үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ө.Ринчинмядаг, аудитор Р.Энхзул, Д.Очирбат, Б.Нямсэмжаан нар 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс 08 дугаар сарын 13-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт "... хүү, торгуулийн орлого" нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан.

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч "хүү, торгуулийн орлого" гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Өвөрхангай аймгийн Төсвийн орлогын ангиллыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Хүснэгт 1. Төсвийн орлогын ангилал (сая.төг)

Орлогын төрөл	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татварын орлого	17,914.7	26,317.3	32,191.7	40,518.6
Татварын бус орлого	46,332.0	42,534.8	54,346.6	53,922.4

Дээрх орлогоос хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 2. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая.төг)

Орлогын төрөл	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Хүүгийн орлого	3,734.8	15.5	1,069.9	-
Торгуулийн орлого	1,495.2	2,436.4	2,005.8	3,154.3

Хүснэгтээс харахад татварын бус орлогын 5.76-5.85 хувийг хүү, торгуулийн орлого эзэлж байна. Дээрх орлого 2023 онд 2,451.89 сая төгрөг байсан бол 2024 онд 3,154.3 сая төгрөг болж 28.65 хувиар өссөн байна.

Торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан аймаг, 19 суманд 2023 онд нийт 641.0 сая, 2024 онд 671.5 сая төгрөгийг тус тус төлөвлөн хуваарилсан байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 27 байгууллагад 174 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд ажиллаж байсан байна

БҮЛЭГ 1. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ХИЙЖ БАЙГАА Ч ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛД ШИНЭЧЛЭЛ, САЙЖРУУЛАЛТ ХИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД НАРИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ТУСГАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөснөөр зарим сумдад орлого бүрэн биелэхгүй, тасрах эрсдэл үүсэж байгаа тул хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийг харгалзах үзүүлэлтүүдийг тусган журамлах нь зүйтэй юм.

А.1.1. Хүүгийн орлогын төрөл зүйлийг нарийвчлан хуульчилж, журамлах шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт "... хүү, торгуулийн орлого" нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан. Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч "хүү, торгуулийн орлого" гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна.

Хүснэгт 3. Өвөрхангай аймгийн Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 2023, 2024 он (сая.төг)

Орлогын төрөл	2023 он		2024 он	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Аймгийн ТЕЗ - Хүүгийн орлого	3,734.8	15.5	1,069.9	-
Нийгмийн даатгалын газар	-	66.1	-	75.8
Баянтээг ХК	10.0	20.1	10.0	91.7

Эх сурвалж: Өвөрхангай аймгийн 2023, 2024 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайлан. Нийгмийн даатгалын сангийн судалгаа, тайлан

Монгол Улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд аймгийн ЗДТГ-тай эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр 2011 онд байгуулсан “Хот байгуулалтын салбарын төсөл МОН-2301” хүрээнд Арвайхээр, Хархорин сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг сайжруулж, орон сууцны 1000 айлын гадна дулаан, цэвэр ус, хэрэглээний шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2017 онд байгуулсан “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3388 төсөл нэмэлт санхүүжилт”-ээр Өвөрхангай аймгийн төвд 3000 м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг ашиглалтад оруулж, Хужирт сумын төвд 310 м3/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн гэрээт ажлыг ашиглалтад оруулсан байдаг. Гэвч үүнийг ашиглагч тал нь хүүгийн төлбөрийг төлж чадахгүй байгаатай холбоотой аймгийн орлого тасарсан байна. /Өвөрхангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаас/. Мөн 2024 онд тус орлого тасарсан байна.

Нийгмийн даатгалын газраас сангийн хүүгийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж байна.

Баянтээг ХК-ийн хувьд 2023, 2024 онуудад бусад орлогоор 10.0 сая төгрөг төлөвлөн харилцах болон хадгаламжийн хүүгийн орлогоос 2023 онд 20.1 сая, 2024 онд 91.7 сая төвлөрүүлэн эх үүсвэрээ нэмэгдүүлсэн байна.

Төсвийн орлогод төлөвлөх хүүгийн орлогыг нарийн төрөлжүүлж /төрөөс олгож буй зээлийн хүү г.м/ хуульчилсан заалт байхгүйгээс үүдэлтэй төлөвлөлтөд тодорхой бус байдал үүсэж байна.

А.1.2. Торгуулийн орлогыг сумдын хүн амын тоо, алслагдсан байдал зэрэг тодорхой нарийн үзүүлэлтүүдэд тулгуурлан төлөвлөх нь зүйтэй юм.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.29-д “ орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь, хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг,” гэж заасны дагуу хүү, торгуулийн орлого нь аймаг болон сумын төсвийн суурь орлогын нэг хэсэг бөгөөд суурь зардалд хуваарилагддаг.

Харин торгуулийн орлого томоохон хүн амын төвлөрөл ихтэй сумдад орлого хангалттай давж биелдэг бол хүн амын төвлөрөл баг, алслагдмал сумдад орлого биелэхгүй байх, тасрах тохиолдлууд байна. Иймд торгуулийн орлогыг бүх сумдад өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөх нь оновчтой биш юм.

Торгууль гэдэг нь нэг талаас иргэдэд дарамт, шийтгэл мэт ойлгогддог боловч зөрчлийн хор уршгийг нөхөн барагдуулах; хууль, журам, дүрэм зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох зорилготой байдаг. Иймд төлөвлөлтийг хэт өндрөөр биш тодорхой үзүүлэлтүүдэд тулгуурлан төлөвлөх нь зүйтэй юм.

А.2. Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн, төлөвлөсөн ч Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг төлөвлөхдөө хульд заасан заалт, хувь хэмжээг баримтлаагүй; босоо тогтолцоотой байгууллагууд улс, орон нутгийн төсөв рүү харилцан адилгүй байдлаар торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.

А.2.1. Торгуулийн орлогын биелэлт нь зарим сумдад биелээгүй тасарсан байдалтай байна.

Хүснэгт 4. Өвөрхангай аймгийн Торгуулийн орлогын төлөвлөгөө, биелэлтийг сумдаар 2022-2024 он (сая.төг)

№	Аймаг, сумын нэр	2022 он			2023 он			2024 он		
		Төл	Гүйц	Гүйц хувь	Төл	Гүйц	Гүйц хувь	Төл	Гүйц	Гүйц хувь
1	Өвөрхангай шууд	212.2	384.3	181	212.00	574.70	271	611.00	844.19	138
2	Бүрд	20.3	17.3	85	28.16	23.74	84	23.78	48.93	206
3	Бат-Өлзий	42.0	33.0	79	44.31	42.00	95	41.64	54.93	132
4	Баруунбаян-Улаан	5.3	5.6	106	6.77	7.73	114	6.73	5.34	79
5	Баянгол	7.2	6.9	96	7.34	9.25	126	7.97	4.85	61
6	Гучин-Ус	5.2	5.6	107	4.57	4.18	91	5.01	3.49	70
7	Есөнзүйл	19.8	13.8	70	21.42	21.66	101	19.37	22.25	115
8	Өлзийт	21.0	8.5	41	18.31	17.24	94	15.30	15.92	104
9	Зүүнбаян-Улаан	7.6	5.9	78	5.55	29.05	523	13.23	11.75	89
10	Хайрхандулаан	25.9	23.7	92	29.84	31.27	105	23.75	23.26	98
11	Нарийнтээл	47.2	64.3	136	60.72	76.16	125	90.44	101.95	113
12	Сант	6.5	11.1	171	3.65	5.78	158	6.82	4.11	60
13	Тарагт	12.2	15.3	126	17.00	11.22	66	15.80	10.55	67
14	Төгрөг	4.7	6.9	147	5.13	7.86	153	6.14	8.39	137
15	Уянга	25.0	19.1	77	23.70	36.34	153	27.57	25.14	91
16	Богд	40.0	22.7	57	22.45	26.92	120	24.25	17.62	73
17	Хужирт	34.3	28.6	83	30.17	64.38	213	40.20	50.23	125
18	Хархорин	397.7	399.5	100	412.09	494.15	120	488.02	637.24	131
19	Арвайхээр	550.0	670.8	122	530.00	952.76	180	530.00	1,253.41	236
20	Баян-Өндөр	16.7	0.0	0	11.97	0.00	0	8.82	10.77	122
Нийт дүн		1500.7	1743.1		1,495.2	2,436.38		2,005.82	3,154.30	

/Эх сурвалж: Өвөрхангай аймгийн 2023, 2024 оны жилийн эцсийн нэгдсэн санхүүгийн тайлан/

Дээрх хүснэгтээс харахад аймгийн нийт дүнгээр орлого 2022 онд 16.1 хувь, 2023 онд 62.95 хувь, 2024 онд 57.23 хувиар давж биелсэн. Харин сумдын хувьд орлогын биелэлт харилцан адилгүй зарим сумдад орлого тасарсан, бүрэн биелээгүй байна. Өмнөх оны гүйцэтгэл өндөр байснаас төлөвлөгөө өсөх, өр төлбөр он дамжих, алдаа зөрчил бага байх, торгууль тавих эрх бүхий албан хаагчид сумдад тогтвортой биш байх зэргээс орлогын төлөвлөгөө биелэхгүй байхад мөн нөлөөлж байна.

А.2.2. Орлогыг төлөвлөхдөө сүүлийн 3 жил тутмын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлд дүгнэлт хийн, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна.

А.2.3. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээллэгийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх зээлийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газартай эргэн төлөгдөх нөхцөлөөр байгуулсан гэрээний дагуу эргэн төлөгдөх хүүгийн төлбөрийг төсөвт төлөвлөж өгсөн ч ашиглагч тал нь хүүгийн төлбөрийг төлж чадахгүй байгаатай холбоотой аймгийн орлого тасарсан байна.

А.2.4. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар зүйлийн 46.1-д заасан зөрчлийн ангилал болон хувь хэмжээг баримтлаагүй байна.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь 2023 онд 4 бүлэг 32 арга хэмжээний хүрээнд 127.0 сая төгрөг, 2024 онд 4 бүлэг 30 арга хэмжээний хүрээнд 127.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн баталсан байна.

Харин аймаг, болон сумдад Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын санхүүжилтийг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар

зүйлийн 46.1-д¹ заасан зөрчлийн ангилал болон хувь хэмжээг нарийн харгалзан үзэхгүй төлөвлөлт хийсэн байна.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймаг болон 19 суманд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар зүйлийн 46.1-д Зөрчлийн тухай хуульд уялдуулан заасан зөрчлийн ангилал, хувь хэмжээгээр нарийн төлөвлөлт хийдэггүй байна.

ШИЙДВЭРЛЭЛТ: Аймаг болон 19 сумын Засаг дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг хуульд заасан ангилал хувь хэмжээний дагуу төлөвлөн холбогдох хууль, журмыг мөрдөн ажиллах тухай зөвлөмжийг хүргүүлэв.

А.2.5. Хүү, торгуулийн орлогыг аймгийн СТСХ, Татварын газар болон сумд тогтмол тооцоо нийлж байгаа ч орлогын ихэнх хувийг бүрдүүлэгч аймгийн Цагдаагийн газартай орлогын бүрдүүлэлтийн илүү, дутууг тогтмол тооцоо нийлээгүй, шалтгааныг бүрэн тодруулаагүй байна.

А.2.6. Нэгдсэн зохицуулалт байхгүйгээс шалтгаалан босоо тогтолцоотой байгууллагууд улс, орон нутгийн төсөв рүү харилцан адилгүй байдлаар торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 27 байгууллагад 174 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд ажиллаж байна.

Хүснэгт 5. Байцаагчдын торгууль тавьсан байдал, орлого төвлөрүүлж буй ангилал

№	Байгууллагын нэр	Байцаагчийн тоо	2023, 2024 онд торгууль тавигдсан эсэх	Торгууль төвлөрүүлдэг дансны дугаар, нэр	Улс/орон нутаг/тухайн байгууллагад төвлөрдөг
1	Статистикийн хэлтэс	3	Үгүй	-	
2	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	3	Тийм	100100000982-Өв.МХГазар - орлого	Орон нутаг
3	Өвөрхангай аймгийн Засаг даргын тамгын газрын цэргийн штаб	1	Үгүй	-	
4	Улсын бүртгэлийн хэлтэс	2	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	Орон нутаг
5	Монгол банкны Өвөрхангай аймаг дахь салбар	3	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	Орон нутаг
6	Нийгмийн даатгалын хэлтэс	27	Тийм	5540021665, 192000178595	Улсын төсөв /сангийн эх үүсвэр/
7	Мал эмнэлгийн газар	17	Тийм	100900000608- Мал эмнэлгийн ерөнхий газрын хяналт шалгалтын орлого	Тухайн байгууллага
8	Татварын газар	8	Тийм	100100000956-Өв.Татварын алданги, 100100000952-Өв.Татварын торгууль	Орон нутаг
9	Аймгийн Засаг даргын Тамгын газар	7	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	Орон нутаг

¹ 46.1.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.2, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 4, 6 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.16, 5.18 дугаар зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 4, 5, 7, 9 дэх хэсэг, 6.21, 6.22 дугаар зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8 дугаар зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

10	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар	1	Үгүй	-	
11	Аймгийн Архивын тасаг	1	Үгүй	-	
12	Гадаадын иргэн харьяатын газар	1	Үгүй	-	
13	Аймгийн Цагдаагийн газар	52	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого, 100100000985-Өв.ЦХ-н хүү торгуулийн орлого	Орон нутаг
14	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	3	Тийм	100100000982-Өв.МХГазар - орлого	Орон нутаг
15	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	4	Үгүй	-	
16	Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар	24	Тийм	100100000982-Өв.МХГазар - орлого /сумд сумын хүү, торгуулийн орлогын данс/	Орон нутаг
17	Эрүүл мэндийн газар	1	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	Орон нутаг
18	Онцгой байдлын газар	5	Тийм	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	Орон нутаг
19	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	1	Тийм	100101800914-Өв.ХХ Татварын бус орлого	Орон нутаг
20	Хүнс, хөдөө аж ахуйн газар	5	Тийм	100900000602-Хяналт шалгалтын орлого	Улсын төсөв
21	Боловсрол шинжлэх ухааны газар	2	Үгүй	-	
22	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар	1	Тийм	100900017401-Гэр бүл, хүүхэд, ЗХГазар н.с	Тухайн байгууллага
23	Аймгийн Соёл, урлагийн газар	1	Үгүй	-	
24	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын зохицуулалтын газар	1	Тийм	100900000602-Хяналт шалгалтын орлого	Улсын төсөв
25	Авто тээврийн үндэсний төв	0	Үгүй	-	
26	Онги Таац Сав газрын захиргаа	0	Үгүй	-	
27	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	0	Үгүй	-	
Нийт дүн		174			

Дээрх хүснэгтээс харахад 2023, 2024 онд торгууль тавьсан 16 байгууллагын 3 нь улсын төсөвт, 2 нь тухайн байгууллагын харьяалах дээд газрын дансанд хүү, торгуулийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Зарим байгууллагад байцаагчийн орон тоо сул, байцаагчийн эрхтэй албан тушаалтан байхгүй зэрэг шалтгаанаар тухайн хамрах салбартаа хяналт хийгдээгүй байна. Мөн ижил босоо тогтолцоотой байгууллагуудын орлого төвлөрүүлэлтийн хувьд орон нутаг руу, улсын төсөв рүү төвлөрөх эсэх нь харилцан адилгүй байна. Иймд аймгийн хэмжээнд тогтмол төвлөрч буй 5 дансны орлогуудтай уялдуулан торгуулийн орлогыг төлөвлөж байна.


А.3. Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад тодорхой хэмжээнд нийцэж байгаа ч орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлагатай байна.

А.3.1. Торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байгаа боловч хүүгийн орлого бүрдүүлэлтийн эрх зүйн орчин дутмаг байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 27 байгууллагад торгуулийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий 174 улсын байцаагч ажиллаж байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байгаа эсэх талаарх санал асуулгыг аймгийн торгуулийн орлого бүрдүүлдэг улсын байцаагч нараас авахад 57 улсын байцаагч хамрагджээ. Энэхүү санал асуулгын дүнгээс харахад:

Дүрслэл 1. Улсын байцаагч нараас авсан санал асуулга



Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан харилцан уялдаатай байна уу? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 26 буюу 45.6 хувь нь Тийм, бүрэн хангаж байгаа бөгөөд хууль, эрх зүйн орчин нь хэрэгцээ шаардлагад нийцсэн, үр дүн уялдаа холбоотой байдаг, 19 буюу 33.3 хувь нь Зарим хууль, журам хоорондын уялдаа дутмаг, тодорхой бус байдал байдаг, 6 буюу 10,5 хувь нь Үгүй, бодит хэрэгцээ шаардлагаас хол зөрүүтэй, зохицуулалт сул, тогтолцоо бүрэн уялдаагүй байдаг, 9 буюу 15,8 хувь нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин:

Торгуулийн орлого бүрдүүлдэг байгууллагууд нь өөр өөрсдийн салбарын хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ авч ажиллаж байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлтийг зохицуулж буй эрх зүйн зохицуулалтууд нь Төсвийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад салбарын хуулиуд байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1-д **“Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино”** хэмээн заасан нь хууль, захиргааны хэм хэмжээний актын хүрээнд шийтгэл ногдуулах үндэслэлийг тодорхой зохицуулж өгсөн байх бөгөөд торгууль ногдуулах эрх бүхий байгууллагуудын эрх зүйн үндсийг тодорхойлж өгчээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6-д Зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтныг Зөрчлийн тухай хуулийн ямар зүйл, заалтын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэхийг тодорхой зааж өгсөн байна.²

Дээрх зохицуулалтуудаас харахад торгуулийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангасан байна.

Хүүгийн орлого бүрдүүлэлтийн хууль, эрх зүйн орчин:

- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд Аймаг болон сумын төсвийн татварын бус орлого нь орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого байхаар зохицуулжээ.

² 6.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-д “Энэ хуулийн 9.1.4-т заасан хүүгийн орлогод барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өр, өглөг, харилцах болон хадгаламжийн данс, баталгаа, батлан даалт, зээл, зээллэг, бонд, өрийн хэрэгсэл болон тэдгээрийн урамшуулал зэрэгтэй шууд холбогдуулан зээлдэгчээс олгосон орлого, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүүгийн орлого гэж үзэх бусад орлого хамаарна” хэмээн заажээ.
- Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд мөнгөн хадгаламжийн хүү, харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тооцохоор зохицуулсан байна.³

Төсвийн тухай хуульд аймаг болон сумын төсвийн татварын бус орлого нь хүү, торгуулийн орлого байхаар зохицуулсан⁴, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан хүүгийн орлого нь хөрөнгийн орлого байхаар, хөрөнгийн орлогод албан татвар ногдуулахаар заасан байна.⁵ Дээрх 2 эрх зүйн зохицуулалт нь төсөвт байгууллагуудын хувьд харилцан уялдаагүй заалтууд байна.

Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн орлого төрийн байгууллагуудад байх боломжтойгоор зохицуулсан байх бөгөөд мөнгөн хадгаламжийн хүүгийн хувьд төрийн байгууллага мөнгөн хадгаламж үүсгэж болохооргүй зохицуулалт байна.

Дээрх зохицуулалтуудаас харахад төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн хүүгийн орлогыг хэрхэн бүрдүүлэх, хүүгийн орлогод ямар орлогыг хамааруулах талаарх нарийн зохицуулсан хууль, эрх зүйн акт байхгүй байгаа нь хүүгийн орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Хүүгийн орлого бүрдүүлэлтийн эрх зүйн орчин дутмаг байна.

А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна.

Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээ:

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтоохоор хуульчилж өгчээ.

Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А-7/08/04 дүгээр “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай” тушаалын 1-д “Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг жилийн 3 хүртэл хувиар тогтоосугай” гэж заасан байна. Энэхүү зохицуулалтын дагуу Төрийн байгууллага, Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдэлд хүү тооцуулах эрх зүйн үндэслэлтэй байна.

Мөнгөн хадгаламжийн хүүгийн хувь хэмжээ:

³ 9.1.Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалаггүй хүн /цаашид "иргэн" гэх/, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно.

9.2.Банкинд мөнгөн хөрөнгө хадгалах болон хадгаламжийн даатгалд даатгуулахтай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

18.1.Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

⁴ 23.7.Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

⁵ 9.1.Хөрөнгийн дараах орлогод албан татвар ногдоно:

9.1.4.хүүгийн орлого.

9.4.Энэ хуулийн 9.1.4-т заасан хүүгийн орлогод барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн хөрөнгөд оролцох эрхтэй эсэхийг үл харгалзан бүх төрлийн өр, өглөг, харилцах болон хадгаламжийн данс, баталгаа, батлан даалт, зээл, зээллэг, бонд, өрийн хэрэгсэл болон тэдгээрийн урамшуулал зэрэгтэй шууд холбогдуулан зээлдэгчээс олгосон орлого, Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүүгийн орлого гэж үзэх бусад орлого хамаарна.

Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Банк Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгийг тэдгээрийн хүсэлтийн дагуу гэрээний үндсэн дээр хадгалж, түүнд хүү төлж болно”, 9.2-д Банкинд мөнгөн хөрөнгө хадгалах болон хадгаламжийн даатгалд даатгуулахтай холбогдсон харилцааг Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиар зохицуулахаар заасан байна.

Дүрслэл 2. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулиас



Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль

13 дугаар зүйл. Мөнгөн хадгаламжийн хүү

13.1. Хадгалагч хуульд заасны дагуу хадгаламжийн хүү болон бусад нөхцөлийг нийтэд ил тод зарлах бөгөөд ийнхүү зарласан хүү, нөхцөлөөс аливаа хэлбэрээр өөрөөр тогтоон хадгалуулагчтай гэрээ байгуулахыг хориглоно.

13.2. Хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ нь хадгаламжийн гэрээнд өөрөөр заасан, эсхүл хадгалуулагчаас хадгаламжийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсан, хадгаламжийн данснаас хуульд заасан үндэслэлээр зарлагын гүйлгээ хийснээс бусад тохиолдолд анх тохиролцсон хэвээр байна.

13.3. Хугацаагүй хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалагчаас өөрчлөх тохиолдолд энэ тухай нийтэд мэдэгдсэнээс хойш нэг сарын дараа хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдсөнд тооцох бөгөөд хүүгийн хэмжээг өөрчилснөөс хойших хугацаанд хийсэн аливаа орлогын тухайд хадгалагчаас өөрчлөн тогтоосон хэмжээгээр хүүг тооцно.

13.4. Энэ хуулийн 13.3-т заасны дагуу өөрчлөлт орсон хадгаламжийн хүүгийн хэмжээг хадгалуулагч зөвшөөрөхгүй тохиолдолд нэмж хийсэн орлогын тухайд хадгалуулахаас татгалзаж болно.

13.5. Хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт Хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох, тооцох аргачлалыг Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавихаар заасны дагуу Монгол банкны ерөнхийлөгч, санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А-106/298 дугаар “Аргачлал батлах тухай” тушаал батлагджээ. Энэхүү тушаалаар мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээг бодох тооцоолол, аргачлал, хугацаа, хувь хэмжээг тодорхой зохицуулжээ.

Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох эрх зүйн актуудаар хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээ тодорхой хуульчлагдсан байна.

А.3.3. Төсвийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудад торгуулийн орлогын талаар нарийвчилж тусгаагүй байгаа нь орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой тодорхойгүй маргаантай заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх талаарх санал асуулгад Улсын байцаагч нар дараах байдлаар хариулжээ. Үүнд:

Дүрслэл 3. Улсын байцаагч нараас авсан санал асуулга



Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлттэй холбоотой тодорхойгүй маргаантай заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна уу? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 16 буюу 28,1 хувь нь Тийм, тодорхойгүй заалтууд нь орлого бүрдүүлэлтийн үйл явцад сөргөөр нөлөөлж байна, 29 буюу 50,9 хувь нь Үгүй, тодорхойгүй маргаантай заалтууд байхгүй, 13 буюу 22,8 хувь нь Мэдэхгүй гэж хариулсан байна.

Торгуулийн орлого бүрдүүлэлтэд дараах тодорхойгүй асуудлууд сөргөөр нөлөөлж байна:

- ✓ Төсвийн тухай хуульд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг нарийвчилж тусгаагүй, хяналт тавьж, хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага, албан тушаалтныг тодорхой заагаагүй;
- ✓ Төрийн байгууллагуудын хүүгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтыг нарийвчлан тодорхой хуульчлаагүй;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгаагүй байгаа нь сөргөөр нөлөөлж байгаа нь аудитын явцад харагдаж байна.

А.3.4. Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа боловч торгууль оногдуулах процессыг хялбар болгох хэрэгцээ шаардлага байна.

Зөрчлийн тухай хуульд “хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцохоор зохицуулсан”⁶ бөгөөд зөрчил үйлдсэн тохиолдолд хүн, хуулийн этгээдэд торгох, нийтэд тустай ажил хийлгэх, баривчлах, эрх хасах шийтгэлийг оногдуулж байна. Үүнийг зураглан харуулбал:

Дүрслэл 4. Зөрчлийн тухай хуулиас




Зөрчлийн тухай хуулиар оногдуулж буй шийтгэлийн дийлэнх хувь нь торгох шийтгэл байна.

Танай байгууллагын оногдуулж буй торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байна уу? гэсэн асуулгад Улсын байцаагч нар дараах байдлаар хариулжээ. Үүнд:

⁶ 1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Дүрслэл 5. Улсын байцаагч нараас авсан санал асуулга



Танай байгууллагын оногдуулж буй торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байна уу? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 40 буюу 70,2 хувь нь Тийм, торгуулийн хэмжээ нь зөрчлийн шинж чанар, нөлөөлөлтэй уялдсан байдаг, 18 буюу 31,6 хувь нь Үгүй, торгуулийн хэмжээ нь зөрчилтэй нь харьцуулахад хэт их эсвэл хэт бага тогтоогддог гэж хариулсан байна.

Торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэж байгаа боловч торгууль оногдуулах процессыг хялбар болгох хэрэгцээ шаардлага байгааг аудитын явцад Улсын байцаагч нар хэлж байлаа. Тухайлбал:

- ✓ Ил задгай хог хаягдалтай холбоотой зөрчил гаргасан үйлдэл нь тодорхой байдаг тул торгууль оногдуулах процессыг хялбар болгож, тухайн зөрчлийг газар дээр нь түргэн шуурхай шалган шийдвэрлэдэг болгох; (цагдаа нар шиг бэлэн бусаар газар дээр нь торгууль оногдуулдаг байх)
- ✓ Зөрчлийн хэргийн материалыг цахимжуулж, цаасан суурьт баримтыг багасгах.

А.3.5. Хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйл. Хууль ёсны зарчим

- ✓ 1.2.3. Тодорхой үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зөрчлийн тухай хуулийн 1.2 дугаар зүйл. Шударга ёсны зарчим


- ✓ 1.3.1. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна.
- ✓ 1.3.2. Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуульд зөрчлийн хэлбэрээс нь шалтгаалан иргэн, хуулийн этгээдэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх заалт байхгүй байгаа нь хууль хэрэглээ бүх нийтэд адил тэгш үйлчилж байгааг илэрхийлэх боловч аудитын явцад хууль хэрэглээ нь бүх нийтэд адил тэгш үйлчилж байгаа эсэхийг дүгнэх боломжгүй байна.

А.3.6. Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна.

Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлагатай байгаа эсэх талаарх санал асуулгад Улсын байцаагч нар дараах байдлаар хариулжээ. Үүнд:

Дүрслэл 6. Улсын байцаагч нараас авсан санал асуулга



Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна уу? гэсэн асуултад нийт санал асуулгад оролцогчдын 16 буюу 28,1 хувь нь Тийм, эрх зүйн орчинд суурь шинэчлэл хийх шаардлага тулгарсан, өнөөгийн нөхцөлд нийцэхгүй байгаа, 25 буюу 43,9 хувь нь Тийм, тодорхой заалтуудыг сайжруулах, уялдаа холбоог нэмэгдүүлэх шаардлага байгаа, 17 буюу 29,8 хувь нь Үгүй, одоогийн эрх зүйн орчин хангалттай бөгөөд нэмэлт өөрчлөлт шаардлагагүй гэж хариулсан байна.

Улсын байцаагч, сумдын ИТХ, Засаг дарга нараас авсан санал асуулгын дүнгээс харахад Орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд нийтлэг байдлаар оруулах дараах шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлага байна:

- ✓ Төсвийн тухай хуульд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг нарийвчилж тусган, хяналт тавьж, хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага, албан тушаалтныг тодорхой болгох;
- ✓ Төрийн байгууллагуудын хүүгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн актыг боловсронгуй болгох;
- ✓ Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгах.

А.3.7. Хүү, торгуулийн орлого нь иргэний өмчийн халдашгүй байдалтай зөрчилдөөгүй байна.

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулж өгсөн. Хуулийн 16.13-д иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг баталгаажуулсан бөгөөд иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаалахаар заажээ.

Хүн халдашгүй, чөлөөтэй байх нь хүний угаас заяасан хувийн эрх бөгөөд энэхүү эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулдаг, хөндлөнгийн хэн боловч дур мэдэн халдаж болохгүй туйлын эрх юм. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх нь:

1. Эрх чөлөөтэй байх
2. Бие, махбодын халдашгүй эрх
3. Орон байрны халдашгүй эрх
4. Нууцын халдашгүй эрх
5. Нэр, төрийн халдашгүй байдал
6. Өмчийн халдашгүй байдал гэсэн 6 төрлийн эрхээс бүрдэх бөгөөд энэхүү эрхэд нь иргэний өмчийн халдашгүй байдал орж байна.

Иргэний халдашгүй эрхэд эрх зүйн зөрчлөөс үүдэн гарах хязгаарлалтыг хуулийн хүрээнд хийж болно:

Эрх зүйн аливаа зөрчлөөс үүдэн хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хуулийн хүрээнд, хуулийн дагуу халдах, хязгаарлах нь холбогдох хуулиудаар нарийвчлан зохицуулагддаг. Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдаж болох эрх бүхий албан тушаалтан гэдэгт шүүх засаглалын эрх мэдлийг

хэрэгжүүлэгч болон энэ ажиллагаанд туслалцаа үзүүлж оролцох төрийн тусгай албан тушаалтнуудыг ойлгоно. **Иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдах үндэслэлд** гэмт хэрэг үйлдсэн буюу **Зөрчил гаргасан нь** нотлогдсон байхаар онолын хувьд тодорхойлжээ.⁷

Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн 4.2 дугаар зүйлийн 2-д “зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах эсэхийг шүүх шийдвэрлэнэ”, 3-д “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй” байхаар зохицуулсан нь онолын ойлголтоос харахад иргэний өмчийн халдашгүй байдалд эрх зүйн зөрчлөөс үүдэн гарах хязгаарлалтыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

БҮЛЭГ 2. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГО НОГДУУЛСАН ДҮНГЭЭС ДУТУУ ТӨВЛӨРСӨН БА ГХУСАХ-НИЙ ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСАН ХУВЬ ХЭМЖЭЭНЭЭС ДУТУУ ХУВААРИЛСАН ХОЛБОГДОХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1. Ногдуулсан хүүгийн орлого бүрэн төвлөрөөгүй, торгуулийн орлого 2023, 2024 онуудад нийт 429.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Б.1.1. Аймгийн хэмжээнд нийт 6 байгууллагын ЭБАТ-уудын тогтоосон торгуулиас 2023 онд 188.2 сая, 2024 онд 241.7 сая төгрөг тус тус дутуу төвлөрсөн байна.

Өвөрхангай аймгийн ТЕЗ-ийн тайланд 2023 онд хүүгийн орлого 3,734.8 сая төгрөг төлөвлөн 15.5 сая төгрөг төвлөрсөн, 2024 онд 1,069.9 сая төгрөг төлөвлөн биелээгүй тасарсан байгаа нь ашиглагч тал хүүгийн төлбөрийг төлж чадахгүй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 6. Торгуулийн орлогын төвлөрүүлэгч байгууллагуудаас илүү, дутуу төвлөрүүлсэн байдал

Түрэмэг 6. Торгуулийн орлогын төвлөрүүлэгч байгууллагуудад илүү, дутуу төвлөрүүлсэн байдал											
Д/Д	Орлого төвлөрүүлэгч байгууллагын нэр	Орлого төвлөрүүлдэг дансны дугаар	2023 он					2024 он			
			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс			Ногдуулсан	Зөрчлийн тоо	Үүнээс	
					Төвлөрсөн	Илүү	Дутуу			Төвлөрсөн	Дутуу
1	Аймгийн Засаг даргын Тамгын газар	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого	53.48	28	49.28		4.2	29.22	26	14.72	14.5
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	100100000982-Өв.МХГазар - орлого	0		0			3	2	1.5	1.5
3	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар	100900000602-Хяналт шалгалтын орлого	1.05	2	1.05			4	3	1	3
4	Аймгийн Татварын газар	100100000952 аймаг, сумдын татварын торгуулийн данс	251.8	123	251.4	0.1	0.5	487.2	99	487.2	0.0
5	Аймгийн Татварын газар	100100000956 аймаг, сумдын татварын алдангийн данс	211.0	36	199.3		11.7	255.2	41	254.0	1.2
6	Цагдаагийн газар	100100000988-Өв.Хүү, торгуулийн орлого, 100100000985-Өв.ЦХ-н хүү торгуулийн орлого	1,365.2	47960	1,193.4		171.8	1,028.0	39518	806.5	221.4
Нийт дүн			1,882.5	48,149.0	1,694.4	0.1	188.2	1,806.6	39,689.0	1,565.0	241.7

Эх сурвалж: Аудитаар 27 торгууль тавих эрх бүхий 27 байгууллагаас авсан судалгааны нэгтгэлээс

⁷ Улсын Их Хурлын Тамгын газар, Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс, судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, “Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх: Онолын үндэслэл, бусад орнуудын туршлага” харьцуулсан судалгаа СТ-18/202 <https://www.parliament.mn/nn/4493/>

Өвөрхангай аймгийн хэмжээнд торгуулийн орлого бүрдүүлсэн 16 байгууллагаас дээрх 6 байгууллагын торгуулиас 2023 онд 188.2 сая төгрөг, 2024 онд 241.7 сая төгрөг тус тус дутуу төвлөрсөн байна. Эдгээр байгууллагуудаас Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь улсын төсөв рүү торгуулиа төвлөрүүлдэг.

Дээрх хүснэгтээс дутуу төлөлтийн хамгийн их хэсгийг эзэлж буй Цагдаагийн байгууллагын торгууль нь бэлэн бус байдлаар оногдуулсан торгуулиудын юм.

Б.1.2.Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023, 2024 онуудад эрх бүхий 17 байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд торгууль тавьсан байна.

Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу прокурор зөрчлийн хэрэг бүртгэлд хяналт тавин ажиллаж байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 27 байгууллагад торгуулийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий 174 улсын байцаагч ажиллаж байсан бөгөөд 2023 онд 2,244.6 сая төгрөгийн 70,312 зөрчил, 2024 онд 2,394.6 сая төгрөгийн 67,041 зөрчил прокурорын байгууллагаас хянагдсан байна.

Хүснэгт 7. Шийдвэрийн төрөл 2023, 2024 он

Огноо	Байгууллага	Шийдвэрийн төрөл				Нийт
		Зөрчлийн хэрэгт	Хялбаршуулсан журмаар шийтгэл оногдуулсан	Газар дээр нь шийтгэл оногдуулсан	Шүүхээс	
2023 он	Цагдаагийн байгууллага	138	2767	65621	1390	69916
	Мэргэжлийн хяналтын байгууллага	1	0	0	0	1
	Гааль	0	0	0	0	0
	Татвар	0	92	0	0	92
	Гадаадын иргэн харьяатын газар	0	0	0	0	0
	Бусад	55	247	0	1	303
	Бүгд	194	3106	65621	1391	70312
2024 он	Цагдаагийн байгууллага	135	4797	60210	1620	66762
	Мэргэжлийн хяналтын байгууллага	0	0	0	0	0
	Гааль	0	0	0	0	0
	Татвар	4	41	0	0	45
	Гадаадын иргэн харьяатын газар	0	0	0	0	0
	Бусад	30	204	0	0	234
	Бүгд	169	5042	60210	1620	67041

Б.1.3. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд 2023 онд 12.3 сая төгрөг, 2024 онд 6.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг тус тус дутуу тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5-т “бүх орлого” гэж заасан.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд аймгийн Хүүгийн орлогыг 2023 онд 3734.8 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 15.5 сая төгрөг, 2024 онд 1069.9 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 0 төгрөг, аймгийн Торгуулийн орлогыг 2023 онд 1495.2 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2436.4 сая төгрөг, 2024 онд 2005.8 сая төгрөгөөр төлөвлөж 3154.3 сая төгрөг төвлөрүүлснээр нэгтгэн тусгасан байна. Харин 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын дансны хуулгатай тулган баталгаажуулахад дараах зөрүү үүслээ. Үүнд:

Хүснэгт 8. 2023, 2024 оны хүү, торгуулийн орлогын дансны хуулганы зөрүү (сая.төг)

Огноо	Орлогын нэр, төрөл	Хүүгийн орлого			Торгуулийн орлого		
		Дансны хуулгаарх орлого	Тайлангаарх орлого	Зөрүү	Дансны хуулгаарх орлого	Тайлангаарх орлого	Зөрүү
2023 он	Аймаг	8.4	8.4	0.0	587.0	574.7	12.3
	Сумд	7.1	7.1	0.0	1861.7	1861.7	0.0
Нийт дүн /2023он/		15.5	15.5	0.0	2448.7	2436.4	12.3
2024 он	Аймаг	0.0	0.0	0.0	850.9	844.2	6.7
	Сумд	0.0	0.0	0.0	2310.1	2310.1	0.0
Нийт дүн /2024он/		0.0	0.0	0.0	3161.0	3154.3	6.7

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн торгуулийн орлого нь Өв.Татварын торгууль/100100000952/, Өв.Татварын алданги /100100000956/, Өв.ЦХ-н хүү торгуулийн орлого /100100000985/, Өв.Хүү, торгуулийн орлого /100100000988/, Өв.МХГазар орлого /100100000982/ дансуудаар төвлөрдөг бөгөөд аймгийн ТЕЗ-ийн нэгтгэсэн тайланд 2023 онд 12.3 сая төгрөг, 2024 онд 1.7 сая төгрөгийн торгуулийн орлогыг тус тус дутуу тайлагнасан байна.

ШИЙДВЭРЛЭЛТ: Торгуулийн орлогыг аймгийн нэгдсэн тайланд дутуу тусгасан зөрчилд аймгийн Засаг даргад зөрчил таслан тогсоох албан шаардлага хүргүүлэв.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт эзлэх хувь харьцангуй бага байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т “Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ”, 23 дугаар зүйлийн 23.3-т “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ” гэж заасан байдаг.

Хүснэгт 9. Аймгийн ТЕЗ-н 2023, 2024 оны санхүүгийн тайланд хүү, торгуулийн орлогын эзлэх хувь

Орлогын нэр, төрөл	2023 он /сая.төгрөгөөр/			2024 он /сая.төгрөгөөр/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
Нийт орлого	64,246.70	68,852.10	100.00%	86,538.30	94,441.00	100.00%
Татварын орлого	17,914.70	26,317.30	38.22%	32,191.70	40,518.60	42.90%
Татварын бус орлого	46,332.00	42,534.80	61.78%	54,346.60	53,922.40	57.10%
Үүнээс: Хүүгийн орлого	3,734.80	15.50	0.04%	1,069.90	-	0.00%
Торгуулийн орлого	1,495.20	2,436.40	5.73%	2,005.80	3,154.30	5.85%

Дээрх хүснэгтээс харахад 2023 онд нийт орлогын 38.22 хувийг татварын орлого, 61.78 хувийг татварын бус эзэлж байгаа бол 2024 онд нийт орлогын 42.9 хувийг татварын орлого, 57.1 хувийг татварын бус орлого тус тус эзэлж байна. Харин 2023 онд татварын бус орлогын 0.04 хувийг хүүгийн орлого, 5.73 хувийг торгуулийн орлого, 2024 онд 5.85 хувийг торгуулийн орлого тус тус эзэлж байна.

Хүснэгт 10. Аймгийн татварын бус орлогыг аймаг, сумдаар задалж харуулбал /сая.төгрөг/

№	Сумдын нэр	Татварын бус орлого /2023он /	Үүнээс:		Хүү, торгуулийн орлогын эзлэх хувь	Татварын бус орлого /2024он/	Үүнээс:		Хүү, торгуулийн орлогын эзлэх хувь
			Хүүгийн орлого	Торгуулийн орлого			Хүүгийн орлого	Торгуулийн орлого	
1	Өвөрхангай шууд	28,998.6	8.4	574.7	2.0	35,585.4	-	844.2	2.4
2	Арвайхээр	2,364.3	-	952.8	40.3	3,091.3	-	1,253.4	40.5
3	Бат-Өлзий	1,139.4	-	42.0	3.7	2,619.0	-	54.9	2.1
4	Баянгол	513.5	-	9.3	1.8	516.0	-	4.9	0.9
5	Баян-Өндөр	513.1	7.1	-	1.4	677.1	-	10.8	1.6
6	Баруунбаян-Улаан	414.7	-	7.7	1.9	432.6	-	5.3	1.2
7	Богд	967.3	-	26.9	2.8	1,054.7	-	17.6	1.7
8	Бүрд	482.1	-	23.7	4.9	881.6	-	48.9	5.5
9	Гучин ус	411.5	-	4.2	1.0	801.0	-	3.5	0.4
10	Есөнзүйл	351.5	-	21.7	6.2	465.0	-	22.3	4.8
11	Зүүнбаян-Улаан	353.8	-	29.1	8.2	451.2	-	11.8	2.6
12	Нарийн тээл	529.9	-	76.2	14.4	1,171.1	-	102.0	8.7
13	Өлзийт	262.5	-	17.2	6.6	344.2	-	15.9	4.6
14	Сант	508.0	-	5.8	1.1	449.6	-	4.1	0.9
15	Тарагт	398.9	-	11.2	2.8	563.9	-	10.6	1.9
16	Төгрөг	525.3	-	7.9	1.5	865.1	-	8.4	1.0
17	Уянга	750.9	-	36.3	4.8	1,003.4	-	25.1	2.5
18	Хайрхандулаан	548.9	-	31.3	5.7	598.3	-	23.3	3.9
19	Хархорин	1,916.0	-	494.2	25.8	1,746.6	-	637.2	36.5
20	Хужирт	584.5	-	64.4	11.0	605.2	-	50.2	8.3
Нийт дүн		42,534.8	15.5	2,436.4		53,922.4	-	3,154.3	

Дээрх хүснэгтээс харахад аймгийн шууд болон бусад 17 сумд татварын бус орлогын 2023 онд 1.0-14.4%-ийг, 2024 онд 0.4-8.7%-ийг хүү, торгуулийн орлоо эзэлж байна. Хархорин, Арвайхээр сумд татварын бус орлогын 2023 онд 25.8-40.3%-ийг, 2024 онд 36.5-40.5%-ийг торгуулийн орлого эзэлж байгаа бол бусад сумд хүү, торгуулийн орлого төсвийн орлогын бусад эх үүсвэрт эзлэх хувь харьцангуй бага байна.

Б.2. Хүү, торгуулиас бүрдсэн орлогоос ГХУСАХ-ний зардалд 359.3 сая төгрөгийг дутуу хуваарилсан бөгөөд холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай байна.

Б.2.1. Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль, эрх зүйн үндэслэл бүрэн бүрдээгүй байна.

Монгол Улсын Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4-т “Аймаг, нийслэлийн ИТХ-аас тухайн жилийн төсвийг батлахдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл /цаашид Зөвлөл гэнэ/-ийн нэрээр тусад нь нэр зааж батлахаас гадна тухайн сум, дүүргийн гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралтыг харгалзан гаргасан хуваарийг үндэслэн сум, дүүрэг тус бүрээр нэр зааж батална. Уг хөрөнгийг сум, дүүргийн батлагдсан төсөв дээр нэмж олгоно” гэж заасан.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 15/06 дугаар тогтоолоор 2023 оны хүү, торгуулийн орлогыг 212.0 сая төгрөг, ГХУС зардлыг 127.0 сая төгрөгөөр, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 23/14 дүгээр тогтоолоор 2024 оны хүү, торгуулийн орлогыг 321.0 сая төгрөг, ГХУС зардлыг 127.0 сая төгрөгөөр тус тус баталсан бол 19 сумд хүү, торгуулийн орлогын төлөвлөлт болон ГХУС зардлыг тухайн сумынхаа ИТХ-аар батлуулж байна. Энэ нь аймгийн ИТХ-с гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан хөрөнгийг сум бүрээр нэр зааж батална гэж заасантай нийцэхгүй байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэгдсэн байхад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам” дагалдан шинэчлэгдээгүй байгаатай холбоотой байна.

Б.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчлэлтэй холбогдуулан дагалдах журмыг шинэчлэн батлах шаардлагатай байна.

Аймаг, сумдын ИТХ нь ГХУС зардлыг төлөвлөхдөө өмнөх оны хүү, торгуулийн орлогын гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байна. Аймгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт 11. Хүүгийн орлого /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Аймаг	3,734.8	8.4136	1,069.9	0
2	Баян-Өндөр		7.099		
	Нийт дүн	3,734.8	15.5	1,069.9	0.0

Хүснэгт 12. Торгуулийн орлого /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	2022 он		2023 он		2024 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Өвөрхангай шууд	212.2	384.3	212.00	574.70	611.00	844.19
2	Бүрд	20.3	17.3	28.16	23.74	23.78	48.93
3	Бат-Өлзий	42.0	33.0	44.31	42.00	41.64	54.93
4	Баруунбаян-Улаан	5.3	5.6	6.77	7.73	6.73	5.34
5	Баянгол	7.2	6.9	7.34	9.25	7.97	4.85
6	Гучин-Ус	5.2	5.6	4.57	4.18	5.01	3.49
7	Есөнзүйл	19.8	13.8	21.42	21.66	19.37	22.25
8	Өлзийт	21.0	8.5	18.31	17.24	15.30	15.92
9	Зүүнбаян-Улаан	7.6	5.9	5.55	29.05	13.23	11.75
10	Хайрхандулаан	25.9	23.7	29.84	31.27	23.75	23.26
11	Нарийн тээл	47.2	64.3	60.72	76.16	90.44	101.95
12	Сант	6.5	11.1	3.65	5.78	6.82	4.11
13	Тарагт	12.2	15.3	17.00	11.22	15.80	10.55
14	Төгрөг	4.7	6.9	5.13	7.86	6.14	8.39
15	Уянга	25.0	19.1	23.70	36.34	27.57	25.14
16	Богд	40.0	22.7	22.45	26.92	24.25	17.62
17	Хужирт	34.3	28.6	30.17	64.38	40.20	50.23
18	Хархорин	397.7	399.5	412.09	494.15	488.02	637.24
19	Арвайхээр	550.0	670.8	530.00	952.76	530.00	1,253.41
20	Баян-Өндөр	16.7	0.0	11.97	0.00	8.82	10.77
	Нийт дүн	1500.7	1743.1	1,495.16	2,436.38	2,005.82	3,154.30

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх заалт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” 2019 онд шинэчлэн батлагдсан боловч дагалдаж журам болох Монгол Улсын Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 тоот тушаалаар баталсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ыг шинэчлээгүй байна.

Б.2.3. Хүү, торгуулийн орлогыг ГХУСАХ-ний зардалд 2023, 2024 онуудад нийт 359.3 сая төгрөгөөр дутуу хуваарилсан байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг тухайн жилд Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуулийн ... зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан

дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ”, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалаар “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.5-т “Батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ” гэж заасан.

Аймаг болон сумдын ГХУСАЗСЗөвлөлийн үйл ажиллагааны зардлыг тухайн шатны ИТХ-аас төлөвлөн баталжээ.

Аймаг, сумын хэмжээнд ГХУСАЗСЗөвлөлд тусгай данс байхгүй бөгөөд ГХУСАХ-ний 2023, 2024 оны зардлыг хуулийн дагуу тооцоолоход дараах байдалтай байна.

Хүснэгт 13. ГХУСАХ-ний 2023, 2024 оны зардлыг тооцсон дүн (сая.төг)

№	Аймаг, сумын нэр	2022 оны торгуулийн орлого	2023 оны ГХУСЗардал			2023 оны торгуулийн орлого	2024 оны ГХУСЗардал		
		Гүйцэтгэл	Хуулийн дагуу зарцуулах /40 хувь/	ИТХ-ын тогтоолоор хуваарилсан дүн	Зөрүү	Гүйцэтгэл	Хуулийн дагуу зарцуулах /40 хувь/	ИТХ-ын тогтоолоор хуваарилсан дүн	Зөрүү
1	Өвөрхангай шууд	384.3	153.7	127.0	26.7	574.7	229.9	127.0	102.9
2	Арвайхээр	670.8	268.3	357.5	-89.2	952.8	381.1	290.6	90.5
3	Бат-Өлзий	33.0	13.2	13.9	-0.7	42.0	16.8	60.1	-43.3
4	Баруунбаян-Улаан	5.6	2.3	2.0	0.3	7.7	3.1	13.6	-10.5
5	Баянгол	6.9	2.8	2.8	0.0	9.3	3.7	3.5	0.2
6	Баян-Өндөр	0.0	0.0	3.5	-3.5	0.0	0.0	3.0	-3.0
7	Богд	22.7	9.1	9.0	0.1	26.9	10.8	9.0	1.8
8	Бүрд	17.3	6.9	13.5	-6.5	23.7	9.5	13.9	-4.4
9	Гучин-Ус	5.6	2.2	8.0	-5.8	4.2	1.7	1.5	0.2
10	Есөнзүйл	13.8	5.5	7.8	-2.2	21.7	8.7	3.5	5.2
11	Зүүнбаян-Улаан	5.9	2.4	3.0	-0.6	29.1	11.6	11.5	0.1
12	Нарийнтээл	64.3	25.7	25.0	0.7	76.2	30.5	27.9	2.5
13	Сант	11.1	4.5	1.0	3.5	5.8	2.3	0.5	1.8
14	Өлзийт	8.5	3.4	2.0	1.4	17.2	6.9	2.0	4.9
15	Тарагт	15.3	6.1	6.0	0.1	11.2	4.5	2.4	2.1
16	Төгрөг	6.9	2.8	2.0	0.8	7.9	3.1	7.9	-4.8
17	Уянга	19.1	7.6	5.0	2.6	36.3	14.5	3.0	11.5
18	Хайрхандулаан	23.7	9.5	3.0	6.5	31.3	12.5	3.0	9.5
19	Хархорин	399.5	159.8	38.0	121.8	494.2	197.7	67.6	130.0
20	Хужирт	28.6	11.4	11.0	0.4	64.4	25.8	20.0	5.8
Нийт дүн		1743.1	697.2	641.0	56.3	2436.4	974.6	671.5	303.0

Эх сурвалж: Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт аудитын судалгаа

Дээрх хүснэгтээс харахад Аймаг, сумдын хэмжээнд ГХУСАХ-ний зардлыг 2023 онд 56.3 сая төгрөг, 2024 онд 303.0 сая төгрөгөөр тус тус дутуу төлөвлөн хуваарилсан байна.

Хүснэгт 14. 2023, 2024 онд ГХУСАХ-ны зардлыг давхар хуваарилсан сумд

№	Байгууллагын нэр	2023 он	2024 он
1	Арвайхээр ЗДТГ	297,520.0	200,570.0
2	Бат-Өлзий ЗДТГ	7,425.0	8,910.0
3	Баруунбаян-Улаан ЗДТГ	-	11,600.0
4	Бүрд ЗДТГ	9,450.0	-
5	Есөнзүйл ЗДТГ	5,760.0	2,000.0
6	Тарагт ЗДТГ	-	2,400.0
7	Төгрөг ЗДТГ	8,910.0	5,500.0
8	Хархорин ЗДТГ	23,040.0	-
Нийт дүн		352,105.0	230,980.0

Эдгээр сумд 2023, 2024 онд ИТХ болон ЗДТГ-ын дансанд ГХУСАХ-ний зардлыг давхар хуваарилан, зарцуулсан байна.

Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга, Өвөрхангай аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг

зохицуулах салбарын зөвлөлийн дарга нарын 46 дугаартай 2023 оны 05 дугаар 01-ний өдрийн Хамтын ажиллагааны гэрээний дагуу аймгийн нийт 36 хамтарсан багийн санхүүжилт болгон 10.8 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Б.2.4. Албан хаагчдийн ажлыг дүгнэхдээ орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээг үзүүлэлт болгон дүгнэдэггүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2-т “Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 7.1 дэх хэсэгт заасан зарчмаас гадна нотолгоонд суурилсан, бодитой, шударга байх зарчмыг баримтална” гэж заасан байдаг.

Иймд Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийг үнэлэхдээ албан тушаалын тодорхойлолт, байгууллагын зорилтод нийцүүлэн чанар, үр дүнд суурилсан байдлаар үнэлж, дүгнэдэг тул хүү, торгуулийн орлогын хэрэгжилт, төвлөрүүлсэн орлогыг ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалзан тооцдоггүй, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайланд дурдаж, тусгайлан дүгнэдэггүй байна.

БҮЛЭГ 3. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН АЙМАГ, СУМАНД ЖУРАМД ЗААСАН ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛСАН БА ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРМЫГ НАРИЙВЧЛАН БОЛОВСРУУЛЖ, ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

В.1. Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан, нийгэм, эдийн засагт тодорхой хэмжээнд зэрэг нөлөө үзүүлсэн байна.

В.1.1. Аймаг, сумдад торгуулийн орлогыг холбогдох журмын дагуу үр ашигтай зарцуулсан ч журамд хуульд нийцүүлэн нарийвчлан заалтуудыг тусган, шинэчлэх шаардлагатай байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.5 “Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй”, 94 дүгээр зүйлийн 94.1 “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно” гэж заасан.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь 2023 онд 4 бүлэг 32 арга хэмжээний хүрээнд 127.0 сая төгрөг, 2024 онд 4 бүлэг 30 арга хэмжээний хүрээнд 127.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн баталсан байна.

Аймаг, сумд 140 гаруй төсөл арга хэмжээнд 2023 онд 296.0 сая төгрөг, 2024 онд 435.2 сая төгрөгийг тус зарцуулсан бөгөөд Тарагт сум 0.9 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Мөн Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журамд 5⁸ зориулалтаар зарцуулахаар

⁸ 1/ хууль сахиулах, нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, байгууллагын дунд зохиох эрх зүйн сургалт, сурталчилгааны зардлыг санхүүжүүлэх ;

2/ хэв журмын урамшилтай эргүүл, жижүүр томилох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах ;

3/ сум, дүүргийн нийгмийн хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг томилох, урамшуулах ;

4/ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг урамшуулах ;

заасан бол Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5-д⁹ 11 зориулалтаар зарцуулахыг хуульчилсан байгаа нь дээрх журмыг шинэчлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Аудитын явцад хийгдсэн тодруулга асуулгаар журмын заалтууд ерөнхий байдлаас үүдэлтэй тус зардлыг захиран зарцуулж буй сумдын ИТХ-ын байгууллагын хувьд хүндрэлтэй ойлгомжгүй байдал үүсдэг тухай саналууд хэлж байсан.

Сумдын ИТХ-с зарцуулагдсан зардлыг анхан шатны баримтаас тулган харахад хоолны зардлууд их гарсан байна. Мөн босоо бүтэцтэй хууль хяналтын байгууллагуудад хөрөнгө шийдвэрлэн зарцуулсан зардлууд Арвайхээр, Хархорин гэх мэт томоохон сумуудад гарсан байна. Энэ нь холбогдох журмын заалт тодорхой нарийвчлаагүй, ерөнхийлөн заасантай холбоотой байна.

Хүснэгт 15. Хархорин сумын ИТХ-с зарцуулсан ГХУСЗ зарцуулалт (сая.төг)

Хүснэгт 10. Хархорин сумын ИТХ-с зарцуулсан ТХУСЗ зарцуулалт (сая.төг)							
№	Огноо	Байгууллагын нэр	Сургалт хийх зардал	Брошюр хэвлүүлэх зардал	Үндсэн хөрөнгө бэлтгэх зардал	Бусад зардал	Нийт зардал
1	2023	Хархорин ИТХ /ГХУСЗ/	1.9	4.8	6.9	1.4	15.0
2	2024		4.2	4.7	15.0	43.8	67.6
Нийт зардал			6.1	9.4	21.9	45.2	82.6

В.1.2. Хүү, торгуулийн орлогыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлж, зарцуулсан гэж үзэх боломжгүй байна.

Аймаг болон сумдын хувьд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зориулалт, арга хэмжээ /82201/-с бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж /210801/, бараа үйлчилгээний бусад зардал /210901/ эдийн засгийн ангиллаар зарцуулж байна.

Эдийн засгийн ангилал бүрээр зардлыг зарцуулаагүй нь Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчиж байгаа ч тус журам Сангийн сайдын 2023 оны “Ангилал шинэчлэн батлах тухай” 211 дугаар тушаалаар хүчингүй болсон хэдий ч системийн хөгжүүлэлтээс шалтгаалан тус журам мөрдөгдөж эхлээгүй байна.

5/гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ гүйцэтгэж байгаад эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгөөр хохирсон тохиолдолд зохих журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж, цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийх зардал болон бусад нөхөн төлбөрийг төлөх;

⁹ 46.5.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;

46.5.2.энэ хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон хүн, хуулийн этгээдийг шагнаж, урамшуулах;

46.5.3.энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлж яваад эрүүл мэндээрээ хохирсон буюу амь нас, алдсан тохиолдолд түүнд болон ар гэрт нь олгох тэтгэвэр, тэтгэмжийн зөрүү, зардал, нөхөн төлбөрийг төлөх;

46.5.4.гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд болон шүүхийн шинжилгээний байгууллагаас хуульд заасан чиг үүрэг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардлыг санхүүжүүлэх;

46.5.5.гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа болон үйлдсэн тухай мэдээллийг иргэдээс авах төлбөрийн зардлыг санхүүжүүлэх;

46.5.6.гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үнэлгээ, судалгаа хийх, тэдгээрийг хэлэлцүүлэх, хуульд заасан дүрэм, журам, заавар боловсруулах;

46.5.7.тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга, ажиллагааны талаарх судалгааны ажилд зарцуулах;

46.5.8.олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалын зардлыг санхүүжүүлэх;

46.5.9.энэ хуулийн 14.2-т заасан Зохицуулах зөвлөлийн орон тооны ажлын албаны үйл ажиллагаа, албан хаагчийн цалин хөлс, Салбар зөвлөлийн орон тооны нарийн бичгийн даргын цалин хөлсний зардлыг санхүүжүүлэх;

46.5.10.авто замын тэмдэг, тэмдэглэлийг шинээр байршуулах, шинэчлэх, засварлах.

46.5.11.хууль тогтоомжид заасан бусад.

В.1.3. Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн арга хэмжээ нь олон нийтэд тодорхой хэмжээнд хүрсэн байна.

Аймгийн ГХУСАЗСЗөвлөл нь:

- Гэр бүл, хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх
- Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Замын хөдөлгөөний осол, хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэргээс урьдчилан сэргийлэх, Архидан согтуурахтай тэмцэх гэсэн 4 дэд зөвлөлтэй бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж 2023, 2024 онд дараах үйл ажиллагааг олон нийтэд хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:
 - “Камержуулалт 4, 5 аян”
 - “Мал мах” нэгдсэн арга хэмжээ
 - “Хамтдаа хэвшүүлж, хамтдаа урагшлая” аян
 - “Та татгалз” аян
 - Асуудал шийдэл эрдэм шинжилгээ, судалгааны ажил
 - Хүүхдийн эрхийг хамгаалалд чиглэсэн видео контентын уралдаан
 - Сургалт хэлэлцүүлгүүд
 - “Одоо л больё” аян
 - “Зүрх бүхэнд хайр бий” нөлөөллийн аян
 - “Урамшуулалт эргүүл” арга хэмжээ
 - “Ногоон бүс Өвөрхангай” камержуулалтын арга хэмжээ
 - “Зүрх сэтгэлийн боловсрол” нөлөөллийн арга хэмжээ

Эдгээр арга хэмжээнүүд нь олон нийтэд дараах байдлаар хүрсэн байна. Үүнд:

- Соён гэгээрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан 38 контент, 6 нэвтрүүлэг, 40 гаруй постер бэлтгэн давхардсан тоогоор 170.0 мянга гаруй иргэд олон нийтэд хүргэсэн
- Цагдаагийн газрын “Эрүүлжүүлэх саатуулах баривчлах” байранд баривчлагдсан 901 иргэн, БОЭТ-ын наркологийн тасагт архины хордлого тайлуулах эмчилгээ хийлгэж буй 57 иргэнд 38 удаагийн сургалт
- “Хамтдаа хэвшүүлж, хамтдаа урагшилъя” аяны хүрээнд Богд, Гучин-Ус, Уянга, Хужирт сумдын иргэдэд сургалт зохион байгуулж 260 гаруй иргэд хамрагджээ
- “Камержуулалт 4, 5” аяны хүрээнд 19 сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайд нийт 405ш теле хяналтын камерыг шинээр суурилуулсан
- Аймгийн Салбар зөвлөлийн дэргэдэх дэд зөвлөлтэй хамтран 40 удаагийн сургалт хэлэлцүүлгийн арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 21300 гаруй иргэд хамрагдсан.

Нийт давхардсан тоогоор 192.5 мянга гаруй иргэн ГХУС арга хэмжээнд хамрагдсан бөгөөд тэдний 88.3% нь соён гэгээрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүрээнд зохион байгуулсан ажлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл авч оролцсон байна.

Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн ГХУС арга хэмжээ нь ард иргэдэд тодорхой хэмжээнд хүрсэн байна.

В.1.4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2024 оны арга хэмжээ нь нийгэм, эдийн засагт эерэг нөлөөг үзүүлсэн байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 2020-2024 онуудад нийт 296,706 гэмт хэрэг, зөрчил бүртгэгдсэн байна.

Дүрслэл 7. 2020-2024 онд бүртгэгдсэн зөрчлийн тоо



/Эх сурвалж-Үндэсний статистикийн хорооны 1212.mn сайт/

Дээрх тоон мэдээллээс харахад зөрчлийн тоо 2021 онд өмнөх оноос 17,251-аар буурсан /Ковид цар тахлаас шалтгаалан/ байна. Харин зөрчлийн тоо 2022, 2023 онуудад ахин өссөн үзүүлэлтээс 2024 онд өмнөх оноос 7,486-аар буурчээ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн 2024 оны арга хэмжээ нь тодорхой хэмжээнд нийгэмд эерэг нөлөөл үзүүлсэн байна.

В.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг ил тод мэдээлээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад ил тод байдлыг хангасан байх гэж заасан. Аймгийн ГХУСАЗСЗ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар цаг үеийн мэдээллийг тухай бүр олон нийтэд мэдээлж байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д¹⁰ төсвийн ил тод байдлыг хангах талаар тодорхой заалтуудыг тусгасан. Тус зардлын зарцуулалтыг олон нийтэд шууд мэдээлсэн талаар тайлан мэдээлэл аймаг сумдын зөвлөлийн хувьд байхгүй байна.

Хүү, торгуулийн орлогын зарцуулалтын ил тод байдалтай холбоотойгоор иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талуудаас албан ёсны үнэлгээ, санал, дүгнэлт ирүүлээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд 46.1-д заасны дагуу торгуулийн орлогын өмнөх оны гүйцэтгэлийн 40-с доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг аймаг, сумдын ИТХ-ын төсөвт суулгаж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулахаар тусгасан. Тус зардлын зарцуулалтын шилэн дансны хөтлөлтийг Төрийн аудитын байгууллага болон Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас жил бүр тогтмол хянаж, шалгаж байна.

Санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим хуудаст мөн ил тод нээлттэй байршуулах заасан. *Аймаг, сумдын ИТХ-ын ГХУСАЗСЗ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг шилэн дансанд мэдээлсэн эсэхийг шалгахад:*

¹⁰ 6.5.Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:
 6.5.1.төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;
 6.5.3.төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
 6.5.5.хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх;
 6.5.6.төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай, төсвийн үйл ажиллагаанд дахь олон нийтийн оролцоог хангаж ажилласан дүнг тэдэнд тухай бүр мэдээлж байх.

! АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Арвайхээр сум 9.3 сая төгрөгийн тогтоол дутуу, аймгийн болон бусад сумдын ИТХ нь хөрөнгө зарцуулах тухай тогтоолоо Шилэн дансны цахим хуудаст огт байршуулаагүй байна.

Шийдвэрлэлт: Аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ГХУСАЗСЗ-д хөрөнгө зарцуулсан шийдвэрээ шилэн дансны сайтад хуулийн хугацаанд оруулж хэвших, олон нийтэд тус зардлын зарцуулалтыг нээлттэй ил тод мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Зураг 1. ГХУСАЗСЗ Тогтоол



Арвайхээр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн тогтоолоос.

Эх сурвалж: <https://shilendans.gov.mn>

Аймгийн хэмжээнд хадгаламжийн хүүгийн орлогыг санхүүгийн тайланд тусгаж шилэн дансны сайтад мэдээлэх үүрэгтэй 2 байгууллага байна.

Нийгмийн даатгалын сан болон Баянтээг ХК-н хувьд 2023, 2024 оны хүүгийн орлогын мэдээллийг шилэн дансанд санхүүгийн жилийн эцсийн тайланд ил тод мэдээлсэн байна.

Хүснэгт 16. Шилэн данс дахь хүүгийн орлогын мэдээлэл

№	Байгууллага	2023	2024	Нийт
1	Нийгмийн даатгалын сан	66.1	75.8	141.9
2	Баянтээг ХК	20.1	91.76	111.86

Эх сурвалж: <https://shilendans.gov.mn>

БҮЛЭГ 4. ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ДУТМАГ БАЙНА.

Г.1. Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрдээгүй байна.

Г.1.1. Байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан үүсээгүй байна.

Өвөрхангай аймгийн хэмжээнд 27 байгууллагад 174 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнууд ажиллаж байгаа бөгөөд байгууллага хооронд мэдээллийн нэгдсэн сан байхгүй байна.

Аймгийн Нийгмийн даатгалын газар, Татварын газар, Цагдаагийн газар, Прокурорын газар нь өөрийн ашигладаг программ хангамжид цахим мэдээллийн сан бүрдүүлж байна.

Нэгдсэн мэдээллийн сан үүсгэх зорилготой Прокурорын ерөнхий газраас “Зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим сан” [/https://ezurchil.gov.mn/](https://ezurchil.gov.mn/) системийг 2023 оноос хэрэглээнд нэвтрүүлж төрийн байгууллагуудын эрх бүхий албан тушаалтанд эрх нээж өгсөн ч ашиглалт хангалтгүй байна.

Торгуулийн мэдээллээ байгууллага бүр өөрийн системээс тухай бүр илгээж улсын хэмжээнд ашиглах мэдээллийн нэгдсэн санг бий болгох хэрэгцээ, шаардлагатай байна. Ингэснээр төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сайжрах, хууль, журмын дагуу гэмт сэргийлэх зардлыг бодитоор төлөвлөх боломж бүрдэнэ.

Г.1.2. Цагдаагийн бэлэн бус торгуулийн төлбөрийн төлөлт бүрэн цахимжсан байна.

Замын цагдаагийн оногдуулсан бэлэн бус торгуулийн төлбөрийг банкны аппликейшн, smartcar.mn, e-mongolia.mn, Гэрэгэ киоск, ebarimt.mn сайтууд болон тухайн сайтын аппликейшны тусламжтайгаар төлөх боломжтой болгож уламжлалт байдлаас татгалзаж торгуулиа төлөх шинэ боломжуудыг нэмэгдүүлснээр торгуулийн төлбөрийн системийн хэрэгжилт хангалттай гэж дүгнэж байна.

Харин шийтгэврийн хуудасны буюу бэлнээр торгож буй процессын хувьд торгуулийн төлөлт хуучны арга барилаар төлбөрийг төлөн баримтыг байцаагчид аваачиж өгснөөр төлөлт бүртгэгдэж байна. Өвөрхангай аймгийн хэмжээнд 2023 онд 1843, 2024 онд 932 зөрчлийг торгуулийн төлөлтийг энэ байдлаар бүртгэжээ.

Г.1.3. Хяналтын систем нь орлого бүрдүүлэлтийн үр дүнд нөлөөлж байна.

Замын цагдаагийн оногдуулсан бэлэн бус торгуулийн мэдээллийн дагуу тээврийн хэрэгслийг оношилгоонд оруулах, худалдан борлуулах үед торгуулиа бүрэн барагдуулсан тохиолдолд дээрх үйлчилгээг үзүүлж байгаа нь хяналтын систем торгуулийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлж байгаагийн хамгийн сайн жишээ байна.

Бусад торгууль оногдуулах эрх бүхий байгууллагууд хүний эрхэнд халдахгүйгээр хяналтын системийг сайжруулах нь зүйтэй юм.

Г.2. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт, иргэн, ТББ, ОУБ, зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Г.2.1. Хугацаа хэтэрсэн, насжилт өндөртэй хүү, торгуулийн орлогыг барагдуулах ажлыг зохион байгуулж, дараагийн шатны арга хэмжээг авч ажилласан байна.

Аймгийн болон Хархорин сум дахь ШШГГ-т 2023, 2024 онд 40.2 сая төгрөгийн 60 зөрчлийн хэргийг албадан гүйцэтгэхээр хүргүүлснээс 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 100% биелэлттэй байна.

Хүснэгт 17. 2023, 2024 онд шүүхээс албадан гүйцэтгүүлхээр хүргүүлсэн зөрчлийн тоо, дүн /сая төг/

Байгууллага	Зөрчлийн тоо	Зөрчлийн дүн	Биелэлт хувь
Аймгийн ШШГГ	30	11.3	100 %
Хархорин ШШГГ	30	28.9	100 %

Эх сурвалж: Аймаг, Хархорин сум дахь ШШГГ-с ирүүлсэн мэдээ

Г.2.2. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт хэрэгжүүлж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна” гэж заасны дагуу шийтгэл оногдуулсан эрх бүхий албан хаагч шийдвэрийнхээ биелэлтийг хариуцан ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журмын 3 дугаар зүйлийн 13-т “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын байгуулалт, зарцуулалтад тухайн шатны Хурал, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавина” гэж заасны дагуу аймгийн ИТХ-р ГХУСАЗСЗ-н ажлын тайланг хэлэлцэж үнэлдэг, Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар жил бүр аймаг, сумын ИТХ-н санхүүгийн тайланд түүвэрчилсэн байдлаар санхүүгийн хяналт шалгалт, шилэн дансны хөтлөлтөд байнгын хяналт хэрэгжүүлж байна.

Г.2.3. Орлого төвлөрүүлэгч байгууллагууд торгуулийн орлогод дотоод хяналт хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2-д “Шийтгэлийн хуудсыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрхлэн хэвлүүлж, аймаг, нийслэлийн санхүү, төрийн сан хариуцсан нэгжид албан хүсэлтийн дагуу бүртгэлээр олгох бөгөөд түүнийг үнэт цаасны нэгэн адил бүртгэж, хадгалалт, зарцуулалтад тухайн эрх бүхий

байгууллагын дарга, нягтлан бодогч хяналт тавина” гэж заасны дагуу Орлого төвлөрүүлэгч байгууллагуудын улсын байцаагч нарт аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн шийтгэлийг хуудсыг олгож байна.

Шийтгэврийн хуудасны бүртгэл, хадгалалт, зарцуулалтад орлого төвлөрүүлэгч байгууллагуудын дарга, нягтлан бодогч хяналт тавихаар журамласан нь учир дутагдалтай байгаа бөгөөд үнэт цаасыг олгож байгаа аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс давхар хяналт хэрэгжүүлэх зохицуулалтыг Засгийн газрын тогтоолд оруулж, хяналтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна. Энэхүү зохицуулалт дутмаг байгаагаас аймгийн СТСХ болон торгуулийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын уялдаат байдал хангалтгүй, торгуулийн төвлөрүүлэлтийг тогтмол тооцоо нийлэхгүй байх нөхцөл байдал бий болж байна.

Г.2.4. Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад иргэн, ТББ, ОУБ, зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана” гэж, мөн 38.2.6-д “гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох” гэж тус тус заасан. 2023, 2024 онуудад иргэд, төрийн бус байгууллага болон хяналтын зөвлөл зэрэг хөндлөнгийн оролцогч байгууллагуудаас зарцуулалт болон хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй байна. Энэ нь тухайн байгууллагын баталсан журамд олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх арга, хэлбэр, үе шат, хариуцсан нэгжийн талаар тодорхой зохицуулалт, зааварчилгаа тусгаагүйтэй холбоотой байв. Үүний улмаас хуульд заасан олон нийтийн хяналтын үр нөлөө бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна.



ДҮГНЭЛТ

- Торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөснөөр зарим сумдад орлого бүрэн биелэхгүй, тасрах эрсдэл үүсэж байгаа тул хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийг харгалзах үзүүлэлтүүдийг тусган журамлах нь зүйтэй юм.
- Хүү, торгуулийн орлогыг гүйцэтгэлд үндэслэн, төлөвлөсөн ч Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг төлөвлөхдөө хульд заасан заалт, хувь хэмжээг баримтлаагүй; босоо тогтолцоотой байгууллагууд улс, орон нутгийн төсөв рүү харилцан адилгүй байдлаар торгуулийн орлогыг төвлөрүүлж байна.
- Хүү, торгуулийн орлого холбогдох хуульд заасан шаардлагад тодорхой хэмжээнд нийцэж байгаа ч орлого бүрдүүлэлтийн эрх зүйн үндэслэлд шинэчлэл, сайжруулалт хийх хэрэгцээ шаардлагатай байна.
- Ногдуулсан хүүгийн орлого бүрэн төвлөрөөгүй, торгуулийн орлого 2023, 2024 онуудад нийт 429.9 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.
- Хүү, торгуулиас бүрдсэн орлогоос ГХУСАХ-ний зардалд 359.3 сая төгрөгийг дутуу хуваарилсан бөгөөд холбогдох журмыг шинэчлэх шаардлагатай байна.
- Төсвийг хуваарилах эрх бүхий байгууллага эрхээ бүрэн хэрэгжүүлэх хууль, эрх зүйн үндэслэл бүрэн бүрдээгүй байна.
- Хүү, торгуулийн орлогыг зориулалтын дагуу зарцуулсан, нийгэм, эдийн засагт тодорхой хэмжээнд эерэг нөлөө үзүүлсэн байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын зарцуулалтыг ил тод мэдээлээгүй байна.
- Хүү, торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүрэн бүрдээгүй байна
- Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт, иргэн, ТББ, ОУБ, зөвлөл зэрэг хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

ДЭЭД ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

- Төсвийн тухай хуульд торгуулийн орлогын бүрдүүлэлтийг нарийвчилж тусган, хяналт тавьж, хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллага, албан тушаалтныг тодорхой болгох;
- Төрийн байгууллагуудын хүүгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн актыг боловсронгуй болгох;
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д татварын бус орлого буюу хүү, торгуулийн орлогын төлөвлөлтийн талаар тодорхой тусгах.
- Нэгдсэн мэдээллийн сан үүсгэх зорилготой Прокурорын ерөнхий газраас “Зөрчлийн бүртгэл мэдээллийн цахим сан” /<https://ezurchil.gov.mn/> системийн ашиглалтыг нэмэгдүүлэх.
- Шийтгэврийн хуудасны бүртгэл, хадгалалт, зарцуулалтад орлого төвлөрүүлэгч байгууллагуудын дарга, нягтлан бодогч хяналт тавихаар журамласан нь учир дутагдалтай байгаа бөгөөд үнэт цаасыг олгож байгаа аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс давхар хяналт хэрэгжүүлэх зохицуулалтыг Засгийн газрын тогтоолд оруулж, хяналтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

ЗӨВЛӨМЖ**Аймгийн ИТХ-ын дарга Т.Нарангарав танаа:**

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө зарцуулсан шийдвэрээ шилэн дансны сайтад хуулийн хугацаанд оруулж хэвших, олон нийтэд тус зардлын зарцуулалтыг нээлттэй ил тод мэдээлж байх.

Засаг дарга О.Пүрэвдорж, аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ц.Идэрсайхан танаа:

- Өвөрхангай аймгийн хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтнуудын ногдуулсан торгуулийн орлого бүрдүүлэлтийн бодит нөхцөл байдлыг судлан, дутуу төвлөрсөн орлогуудтай холбоотой нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, байгууллага хоорондын уялдаат байдлыг сайжруулахад анхаарах, үүнтэй уялдуулан торгуулийн орлогын төлөвлөлтийг хийх
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар зүйлийн 46.1-д Зөрчлийн тухай хуульд уялдуулан заасан зөрчлийн ангилал, хувь хэжээгээр нарийн төлөвлөлт хийх.

Сумдын Засаг дарга нарт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлыг төлөвлөхдөө Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 46 дугаар зүйлийн 46.1-д Зөрчлийн тухай хуульд уялдуулан заасан зөрчлийн ангилал, хувь хэжээгээр нарийн төлөвлөлт хийх.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөрөнгө зарцуулсан шийдвэрээ шилэн дансны сайтад хуулийн хугацаанд оруулж хэвших, олон нийтэд тус зардлын зарцуулалтыг нээлттэй ил тод мэдээлж байх.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

